

САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2008 оны 2 дугаар сарын
12-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 8.1.4, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 9.1, 11.2, Монгол Улсын нэгдсэн төсвийн хуулийн 6.1.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

Нэг. “Улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах журам” -ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. “Улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах журам”-ыг 2008 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Гурав. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого, зохицуулалтын газар /Б.Батжаргал/, Төрийн сангийн газар /С.Мягмардаш/, Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Цогтбаатар/-т тус тус даалгасугай.

Дөрөв. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2006 оны 395 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ч.УЛААН

**УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ
САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ,
БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ИХ ЗАСВАР, ХУДАЛДАН АВАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ХӨРӨНГИЙГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ, ГҮЙЦЭТГЭЛ ГАРГАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын болон орон нутгийн төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмж (цаашид төсвийн хөрөнгө оруулалт гэх)-ийг төлөвлөх, гүйцэтгэлийг хянах, санхүүжүүлэх, хяналт тавих, ажлын гүйцэтгэл гаргах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хууль, Засгийн газрын шийдвэр, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, тайлагнах, гүйцэтгэл гаргах, мэдээлэх үүргийг Төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч яам, газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцна.

1.3. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, төлөвлөгөө боловсруулах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн гүйцэтгэлийг хянах, санхүүжүүлэх, хяналт тавих, ажлын гүйцэтгэл мэдээлэл гаргах, тайлагнах үйл ажиллагааны маягт бүх түвшинд адил байна.

1.4. Төсвийн ерөнхийлөн захирагчид, захиалагч яам, газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Төрийн сан нь хуульчлан батлагдсан төсөл, арга хэмжээ нэг бүрийн хөрөнгийн хэмжээг хатуу баримтлан хяналт тавьж ажиллана.

1.5. Улсын болон орон нутгийн төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэн санхүүжүүлэхийг хориглоно.

1.6. Салбарын яам, газар, аймаг, нийслэл нь төсвийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүр дээр батлагдсан хөрөнгийн хэмжээнд багтаан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер зарлаж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллах бөгөөд хөрөнгийг хэтрүүлэн зарцуулахыг хориглоно.

Хоёр. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ
барилга байгууламжийг төлөвлөх

2.1. Төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч яам, газар, аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг сонгож төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтална.
Үүнд:

- Төрөөс баримталж байгаа Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хэтийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах;

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Монголыг дэмжигч, хандивлагч орнууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагатай Засгийн газар хоорондын шугамаар байгуулсан гэрээ хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн Монголын талын хүлээсэн үүргийг ханган биелүүлэх;
- Салбарын болон бүс нутгийн дунд хугацааны стратеги, мастер төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдолтой төслүүд байх;
- Салбарын хөгжлийн бодлого, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд тусгагдсан байх;
- Шинээр баригдах барилга байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоог харгалзаж үзэх. Нийгмийн шинж чанартай барилга байгууламжийн хувьд түүнийг барих зайлшгүй шаардлага, хэрэгцээ, зардлын тооцоо, зураг төсвийг үндэслэх;
- Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэр бүхий орон нутагт хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий төслүүдийг орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тэргүүн ээлжинд тусгасан байх;

2.2. Тухайн санхүүгийн жилд шинээр эхлэхээр тооцож буй төсөл, арга хэмжээ, барилга байгууламж нь 2.1-д заасан ерөнхий шаардлагыг хангасан байхын зэрэгцээ хайгуул, зураг төслийн ажил нь хийгдсэн, инженерийн сүлжээний хангамжийн асуудал шийдэгдсэн, үр ашигтай нь техник эдийн засгийн тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажил эхлэх нөхцлийг хангасан байна.

2.3. Аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг төлөвлөхдөө тухайн салбарын бодлого, чиглэлийн яам, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг тусгасан байвал зохино.

2.4. Төсвийн хөрөнгөөр хийх их засварын ажлыг төлөвлөхдөө тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох материалыг үндэслэнэ.

Тухайн санхүүгийн жилд зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах тэргүүлэх ач холбогдол бүхий төслийн жагсаалтыг тусгайлан гаргаж, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамт ирүүлнэ.

2.5. Захиалагч яам, газар, аймаг нийслэлийн санхүүгийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй харилцан уялдсан, нэгдмэл байна.

2.6. Захиалагч яам, газар төсвийн хүрээний мэдэгдлийг үндэслэн аймаг, орон нутгийн хэрэгцээ, саналыг салбарын бодлоготой уялдуулан, өгөгдсөн санхүүгийн эх үүсвэрийн хэмжээнд багтаан төслийг боловсруулна.

2.7. Захиалагч яам, газар, аймаг, нийслэл нь тухайн жилийн төсвийн хөрөнгө оруулалт, их засварын ажлын төлөвлөгөөний төслийг сайдын зөвлөл, тэргүүлэгчдийнхээ хурлаар хэлэлцэж гаргасан холбогдох шийдвэр, тайлбар, танилцуулгын хамт ирүүлнэ.

2.8. Захиалагч яам, газар, аймаг, нийслэл нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал, тооцоог “маягт №ХО-1” –ийн дагуу гаргаж холбогдох бусад материалын хамт хуулинд заасан хугацаанд Сангийн яаманд ирүүлнэ.

Гурав. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд төсвийн санхүүжилтийн гэрээ байгуулан эрх шилжүүлсэн төсөл болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт нь тухайн аймаг, нийслэлийн төрийн сангаар дамжин захиалагчийн төрийн сан дахь дансаар санхүүжигдэнэ.

3.2. Аймаг, нийслэлд гэрээгээр эрх шилжээгүй буюу энэ журмын 3.1 дэх заалтад хамрагдаагүй, Төсвийн ерөнхийлөн захирагчийн өөрийн шууд хяналтад байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газар хяналт тавьж Төрийн сангийн газраар дамжин захиалагчийн төрийн сан дахь дансаар санхүүжигдэнэ.

3.3 Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газар, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Санхүү, эдийн засгийн бодлого, зохицуулалтын хэлтэс нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ яам, газар, захиалагчийн барилга объект нэг бүрийн ажлын баталгаажсан гүйцэтгэлийг үндэслэн эрх нээж өгнө.

3.4 Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газар, аймаг, нийслэлийн Санхүү, эдийн засгийн бодлого, зохицуулалтын хэлтэс нь төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засварын ажил, угсрагдахгүй тоног төхөөрөмжийг батлагдсан хөрөнгө оруулалт болон Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний дагуу дор дурдсан баримт, материалыг үндэслэн санхүүжүүлэх эрх нээнэ. Үүнд:

а/ Тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, гэрээ байгуулах эрх олгосон тухай албан тоот, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.4-т заасан босго үнэд хүрсэн бол мөн хуулийн 53.3-т заасан зөвшөөрлийн бичиг.

б/ Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ /Сангийн сайдын 2006 оны 418 дугаар тушаалаар батлагдсан ажлын “Гэрээний загвар” –ын дагуу /,

в/ Гүйцэтгэлийн баталгаа /Сангийн сайдын 2006 оны 418 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн баталгааны маяг”-ын дагуу, хуулийн хүрээнд/,

г/ Урьдчилгаа төлбөрийн баталгаа /Сангийн сайдын 2006 оны 418 дугаар тушаалаар батлагдсан “Урьдчилгаа төлбөрийн баталгааны маяг”-ын дагуу, хуулийн хүрээнд/,

д/ Захиалагчийн хянаж баталгаажуулсан барилгын ажлын гүйцэтгэл,

е/ Барилга, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан тухай улсын болон орон нутгийн комиссын акт,

ё/ угсрагдахгүй тоног төхөөрөмж, зураг төсөв, техник-эдийн засгийн үндэслэлийг тухайн төсвийн ерөнхий менежерийн шийдвэрээр байгуулагдсан ажлын комиссын акт,

ж/ Захиалагчийн санхүүжилт хүссэн тухай албан тоот,

3.5. Тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, гэрээ байгуулах эрх олгосон тухай албан тоот, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд зохих журмын дагуу байгуулсан гэрээ, захиалагчийн санхүүжилт хүссэн албан тоот зэргийг үндэслэн эхний удаа тухайн барилга, их засварын ажлын гэрээний үнийн /хэрэв он дамжих бол тухайн жилд санхүүжүүлэх хөрөнгийн/ 30 хүртлэх хувийн урьдчилгаа олгож болно.

3.6. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, их засварын ажлын урьдчилгаа санхүүжилтын дараа захиалагчийн хянаж баталгаажуулсан гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлэх бөгөөд тухайн төслийг ашиглалтад хүлээн авсан улсын болон орон нутгийн комиссын актыг үндэслэн эцсийн тооцоог хийж үлдэх хөрөнгийн эрхийг

нээж санхүүжүүлнэ. Тухайн төслийг ашиглалтад хүлээн авсаны дараа олгох /үлдэх/ хөрөнгийн хэмжээ нь батлагдсан хөрөнгийн 10 хувьтай тэнцүү байна.

3.7. Захиалагчийн худалдан авах тоног төхөөрөмж 150 саяаас дээш төгрөгийн өртөгтэй байвал 3.4 дүгээр зүйлд заасан холбогдох материалыг үндэслэн 30 хүртэлх хувийн урьдчилгаа санхүүжилт олгож болно.

3.8. Зураг төсөв, техник-эдийн засгийн үндэслэл, тооцоо боловсруулахад урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Зохих журмын дагуу боловсруулж баталгаажуулсан зураг төсөв, техник-эдийн засгийн үндэслэлийг захиалагч хүлээн авсан тухай акт, 3.4 дүгээр зүйлд заасан холбогдох материалыг үндэслэн санхүүжүүлнэ. Харин дотроо олон барилга байгууламж бүхий томоохон цогцолбор арга хэмжээний нэгдсэн зураг төсөв боловсруулахад холбогдох баримт, материалыг үндэслэн энэхүү журмын дагуу урьдчилгаа санхүүжилт олгож болно.

3.9. Захиалагч болон гүйцэтгэгч байгууллага үйлчилж буй хуулийн хүрээнд зохих шаардлагын дагуу банкнаас урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаж ирүүлсэн бол гаргасан баталгаатай тэнцүү хэмжээгээр урьдчилгаа санхүүжилтийг олгож болно. Гүйцэтгэгчийн гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг захиалагч хянан шалгаж санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлнэ.

3.10. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 30 хүртэлх сая төгрөгийн барилга, их засварын ажилд урьдчилгаа санхүүжилт олгохгүй.

3.11. Худалдан авах ажиллагааны хууль, тогтоомж зөрчиж гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

3.12. Барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлийг тухайн объектын батлагдсан төсвийг үндэслэн гүйцэтгэгч байгууллага гаргаж, захиалагч ажил нэг бүрээр нь тулган шалгаж баталгаажуулсан байна. Гүйцэтгэлийн баталгааг захиалагч бүрэн хариуцна.

3.13. Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл, ашиглалтад хүлээн авах актыг барилгын салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан, мөрдөж байгаа журам, дүрэм, маягтын дагуу үйлдэнэ.

3.14. Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газар, аймаг, нийслэлийн Санхүү, эдийн засгийн бодлого, зохицуулалтын хэлтэс энэхүү журмын 3.4-т заасан материалыг бүрэн хүлээн авсанаас хойш ажлын 2 өдрийн дотор хянаж эрх нээнэ. Төрийн сангийн газар нь нээгдсэн эрхийн дагуу холбогдох хууль, журамд нийцүүлэн ажлын 2 хоногт багтаан тухайн төслийг санхүүжүүлнэ.

3.15. Захиалагч байгууллага өөрийн дансанд санхүүжилт орсноос хойш 2 хоногийн дотор гүйцэтгэгч байгууллагад санхүүжүүлт олгоно. Хэрэв захиалагч шаардсан хугацаанд гүйцэтгэгчид хөрөнгийг шилжүүлэхгүй бол хөрөнгийг Төрийн сангийн дансанд татаж, захиалагчийн саналыг үндэслэн гүйцэтгэгчийн дансанд шууд шилжүүлнэ.

3.16. Нээгдсэн эрхийн дагуу шилжүүлсэн хөрөнгөнөөс Захиалагч яам, газар болон аймаг, нийслэлийн төрийн сан нь холбогдох баримтыг үндэслэн барилгын ажлын зардал, зураг төсвийн үнэ, техник хяналтын зардлыг тус тусын дансанд нь баримтын дагуу шилжүүлнэ.

3.17. Захиалагчийн төрийн сан дахь хөрөнгө оруулалтын төсвийн данс банкны жилийн эцсийн тайлангаар үлдэгдэлгүй байх бөгөөд энэ заалт барьцаа хөрөнгөнд хамаарахгүй.

3.18. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эрхийг хавсралт “маягт №Э-1” –ийн дагуу бичиж Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга, тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн, орон нутагт аймаг, нийслэлийн Санхүү, эдийн засгийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн нар гарын үсэг зурж, төрийн санд шилжүүлнэ.

3.19. Тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тодотгол, зохицуулалт хийх шаардлага гарвал Сангийн яам захиалагч байгууллагуудад мэдэгдэн тэдний санал хүсэлтийг авч тооцоог хянан үзэж захиалагчийн хөрөнгө оруулалтын нийт дүнд болон батлагдсан хөрөнгийн эх үүсвэрийн дүнд багтаан шийдвэрлэх санал боловсруулан Засгийн газар, Улсын Их Хуралд оруулна.

3.20. Тухайн жилийн төсвийн тухай хуульд нийт дүнгээр батлагдсан тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагч болон захиалагчийн саналыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар нэр, байршил, төсөл нэг бүрээр нь жагсаалт гаргаж батална.

3.21. Сангийн сайдын тушаалаар батлагдсан их засварын ажлын задаргаанд зохицуулалт хийх шаардлага гарвал захиалагч байгууллагын санал, тооцоог үндэслэн тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн их засварын ажлын батлагдсан дүнд багтаан Сангийн сайдын тушаалаар зохицуулж болно.

3.22. Төсвөөс дараа төлөгдөх нөхцлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг жилийн төсвийн төсөлд тусгах, гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, техникийн хяналт тавих, ажлын гүйцэтгэл хянаж баталгаажуулах, ашиглалтад хүлээн авах, төлбөр олгох шийдэл гаргах бүх үйл ажиллагааг тухайн Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцах бөгөөд объектийг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа барилга байгууламжийн нэг адил үзнэ.

3.23. Төсвийн хөрөнгөөр барилга худалдан авах тохиолдолд захиалагч байгууллага холбогдох тооцоо, судалгааг гарган Засгийн газарт, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бол аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд оруулан чиглэл авсаны дараа мэргэжлийн хүмүүсийг оролцуулсан ажлын хэсэг байгуулан тухайн барилгын талаар үнэлэлт, дүгнэлт гаргаж, түүний үр дүнг үндэслэн актаар хүлээн авна.

3.24. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан гүйцэтгэлийн эцсийн дүнгээр тухайн төсөл хэрэгжсэн төсөвт байгууллагын санхүүд бүртгүүлэн, тайлан баланст нь тусгах арга хэмжээг Захиалагч байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

3.25. Тухайн төслийн тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж, ажил гүйцэтгэх гэрээ, ажлын гүйцэтгэл, нээсэн эрх, ашиглалтад хүлээн авсан комиссын акт, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаа, төсөлтэй холбогдох бусад баримт, мэдээллийг төсөл хэрэгжиж дууссаны дараа зохих журмын дагуу архивлана.

Дөрөв. Хяналт, шалгалт

4.1. Захиалагч нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажлыг явуулах, түүнд техникийн хяналт тавих, шалгалт хийх, ашиглалтад хүлээн авах ажлыг барилгын салбарт мөрдөж байгаа хууль болон барилгын салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан норм, дүрэм, журмын дагуу явуулна.

4.2. Сангийн яам шаардлагатай гэж үзвэл дангаараа болон холбогдох бусад байгууллагыг оролцуулан хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилт, ажлын явц, санхүүжилт болон хөрөнгийн зарцуулалтын байдалтай газар дээр нь үзэж танилцах, шалгах ажлыг зохион байгуулан илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авна.

4.3. Төсвийн ерөнхийлөн захирагч яам, газар нь өөрийн шууд захиалгатай төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянаж ажиллахын хамт аймаг, нийслэлд гэрээгээр санхүүжилтийн эрх шилжүүлсэн барилга, их засварын ажлын гүйцэтгэл, санхүүжилт, ажлын явцын талаар байнга хяналт тавьж байна. Шаардлагатай гэж үзвэл дангаар болон аймаг, нийслэлийн ЗДТГ, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран үзлэг, шалгалт хийж шаардагдах арга хэмжээг тухай бүр авч ажиллана.

4.4 Төсвийн хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэлийн явц, хөрөнгийн зарцуулалтыг Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газар, аймаг, нийслэлийн ЗДТГ, Санхүү, эдийн засгийн бодлого, зохицуулалтын хэлтэс газар дээр нь үзэж танилцах, хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах, шаардлагатай тохиолдолд санхүүжилтийг түр зогсоох арга хэмжээ авч болно.

4.5. Илэрсэн зөрчлийг арилгах, тавьсан шаардлагыг биелүүлээгүй, эргэн шалгуулж тайлагнаагүй захиалагч, гүйцэтгэгчийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг түр зогсоох, холбогдох хяналтын байгууллагад хүсэлт тавьж дахин шалгуулах арга хэмжээ авч ажиллана.

4.6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, ажлын явц, санхүүжилтийн байдлыг аймаг, нийслэлийн ЗДТГ тухай бүр хэлэлцэж, арга хэмжээ авах, шаардлагатай бол ИТХ-д оруулан шийдвэрлүүлнэ. Хяналтын ажлыг төв, орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран хийж болно.

Тав. Гүйцэтгэлийн мэдээлэл гаргах тухай

5.1. Улсын төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ, ажлын явцын талаарх мэдээллийг Төсвийн ерөнхийлөн захирагч, яам, газар сар бүр гаргаж Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлнэ.

5.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтэс нь бүтээгдэхүүн нийлүүлэх төсвийн санхүүжилтийн гэрээ байгуулан эрх шилжүүлэн авсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ, ажлын явцын талаарх мэдээллийг гэрээ байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагчид болон Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газарт сар бүр гаргаж ирүүлнэ.

5.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ, ажлын явцын талаарх мэдээллийг улирал бүр гаргаж Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлнэ.

5.4. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ, ажлын явцын талаарх мэдээллийг сар бүрийн эхний ажлын 3 хоногт, орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ, ажлын явцын талаарх мэдээллийг дараа улирлын эхний сарын 5-ны өдрийн дотор гаргаж холбогдох газруудад нь хүргүүлсэн байна.

5.5. Төсвийн ерөнхийлөн захирагч, яам, газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь ирүүлсэн мэдээллийн чанар, бодит байдал, баталгааг өөрсдөө хариуцна.

5.6. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ, ажлын явцын талаарх мэдээлэл нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зохицуулалт болон цаашид авах арга хэмжээний бодлого, чиглэл гаргах ажлын шаардлага хангахгүй байвал мэдээллийг дахин авах бөгөөд чанаргүй мэдээллээс үүсэх хариуцлагыг захиалагч хариуцна.

5.7. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ, ажлын явцын талаарх мэдээллийг энэ журмын хавсралтад байгаа “Маягт №2”б”, “Маягт №2”в”, “Маягт №2”г”, “Маягт №2”д”-н дагуу гаргана.

Зургаа. Хариуцлагын тухай

6.1. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах үйл ажиллагаанд дараах зөрчил гаргасан албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ: Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд зураг төсөв, ТЭЗҮ, холбогдох бусад үндэслэл нь тодорхой бус барилга байгууламж, их засварын ажил, үр ашиггүй төсөл тусгасан.
- Тухайн жилийн төсвийн тухай хууль, эрх бүхий байгууллагаас баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тусгагдаагүй барилга байгууламж, их засварын ажлыг нэмж оруулсан.
- Барилга байгууламж, их засварын гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлийг буруу гаргасан, түүнийг баталгаажуулсан.
- Батлагдсан хөрөнгө оруулалтын төслийг ажлын гүйцэтгэл гараагүй байхад санхүүжүүлсэн. Мөн батлагдсан хөрөнгөнөөс илүү гаргаж санхүүжүүлсэн.
- Батлагдсан хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөөнд тусгагдаагүй төслийг санхүүжүүлсэн.
- Ажлын гүйцэтгэл, холбогдох баримт нь зохих журмын дагуу бүрэн ирсэн байхад эрх нээгээгүй, санхүүжилтийг хугацаанд нь хийгээгүй.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг сольсон, мөн хөрөнгө оруулалт, их засварын ажил, угсрагдахгүй тоног төхөөрөмжийн хөрөнгийн зардлыг хооронд нь шилжүүлсэн.
- Хөрөнгө оруулалтын мэдээ, тайланг хугацаанд нь гаргаагүй, буруу мэдээлсэн.

- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэн ашиглалтад хүлээн авсан барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмжийг санхүүгийн бүртгэл, тайлан баланст тусгаагүй бол.
- Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний техникийн болон ажлын гүйцэтгэлийн хяналтыг зохих журмын дагуу хийгээгүй зэрэг болно.

--- 000 ---

Улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах журмын хавсралт “маяг № ХО-1”

Батлав:сайд, / дарга/ /

Захиалагч: яам /газар/

Төсвийн хөрөнгө оруулалтаар..... оны санхүүгийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөл
/сая.төгрөг/

дд	Төсөл , арга хэмжээний нэр, байршил	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	200... онд санхүүжүүлэх хөрөнгө	Объектын талаарх товч тайлбар
а	Б	1	2	3	4
	I.Хөрөнгө оруулалт:дүн				
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр				
1					
2					
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр				
1					
2					
	II. Их засвар:дүн				
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр				
1					
2					
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр				
1					
2					
	III.Тоног төхөөрөмж: дүн				
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр				
1					
2					
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр				
1					
2					
	Бүгд дүн				

Зөвшөөрсөн: Төсвийн ерөнхий менежер /

Хөрөнгө оруулалтын төслийг хянаж боловсруулсан яам /газар/-н:

1. Газрын дарга /


2. Хэлтсийн дарга /

3. Мэргэжилтэн /

Харилцах утас №:

200... оны дугаар сарын ... ны өдөр

Улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах журмын хавсралт “маяг № 3-1”



САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭГДЭЛ

2008 оны дугаар сарын ...-ны өдөр

Санхүүжилтийн дүн тоогоор, үсгээр байна.

Захиалагч, гүйцэтгэгч байгууллагын нэр	Барилга, байгууламж, төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүч чадал /юуны санхүүжилт болох/	Банкны нэр, дансны дугаар	Мөнгөний дүн /төг/
Захиалагч: БСШУЯам Гүйцэтгэгч:	Сургууль спорт заалны хамт, 640 суудал, Увс аймаг Улаангом /барилга угсралтын ажлын гүйцэтгэл/	Төрийн сан, данс №	10175245,0 /арван сая нэг зуун далан таван мянга хоёр зуун дөчин тав/

Санхүүжилтийн эрх нээсэн:

Санхүүжүүлэх ажлын төрлийг бичнэ. Ж-нь: барилга угсралын ажил, зураг төсөв, хайгуул гэх мэт.

Захиалагчийн төрийн сан дахь данс

Гарын үсэг: 1. /

/ Сангийн яамны ТБЗГ-ын дарга
(...аймгийн СЭЗБЗХ-ийн дарга)

2. /

/ Сангийн яамны ТБЗГ-ын ХОХ-ийн
мэргэжилтэн
(... аймгийн СЭЗБЗХ-ийн
хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн)

Улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах журмын хавсралт “маят № 2”б”

Аймаг, нийслэлд эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

Батлав:аймгийн Засаг дарга /

ТЕЗ яам, газруудын захиалгаар 2008 оны санхүүгийн жилд аймагт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл
/...-р сарын мэдээ, сая.төгрөг/

дд	Төсөл , арга хэмжээний нэр, байршил	Хэрэг-жүүлэх Хугацаа	Гэрээний дугаар	гэрээнд тусгасан төсөвт өртөг	2008 онд санхүүжүүлэх батлагдсан хэмжээ	Санхүүж илтийн гүйцэтгэл өссөн дүнгээр	Объектын ажлын явцын талаарх товч тайлбар
а	Б	1	2	3	4	5	6
	а/БСШУЯам						
	I.Хөрөнгө оруулалт:дүн						
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр						
1							
2							
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр						
1							
2							
	II. Их засвар:дүн						
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр						
1							
2							
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр						
1							
2							
	III.Тоног төхөөрөмж: дүн						
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр						
1							
2							
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр						
1							
2							
	Бүгд						
	б/ХХААЯам						
	в/НХХЯам						
	г/ЭМЯам ГЭХ мэт						
	Бүгд дүн						

*Гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 03-ны өдрийн дотор гаргаж ТЕЗ-чид болон Сангийн яамны ТБЗГ, ТСГ-т хүргүүлнэ.

Зөвшөөрсөн: Төсвийн ерөнхий менежер /

Гүйцэтгэл хянаж боловсруулсан аймгийн:

1. СЭЗБЗХэлтсийн дарга /
2. Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн. /
3. Төрийн сангийн мэргэжилтэн /

2008 оны дугаар сарынны өдөр

Улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах журмын хавсралт “маят № 2”В”

Батлав:аймгийн Засаг дарга / /

2008 оны санхүүгийн жилд аймагт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл /....-р улирлын мэдээ, сая.төгрөг/

дд	Төсөл , арга хэмжээний нэр, байршил	Хэрэг-жүүлэх Хугацаа	Гэрээний дугаар	гэрээнд тусгасан төсөвт өртөг	2008 онд санхүүжүүлэх батлагдсан хэмжээ	Санхүүж илтийн гүйцэтгэл өссөн дүнгээр	Объектын ажлын явцын талаарх товч тайлбар
а	Б	1	2	3	4	5	6
	I.Хөрөнгө оруулалт:дүн						
1							
2							
3							
4							
5							
	II. Их засвар:дүн						
1							
2							
3							
4							
5							
	III.Тоног төхөөрөмж: дүн						
1							
2							
3							
4							
5							
	Бүгд дүн						

*Гүйцэтгэлийн мэдээг улирал бүр гаргаж Сангийн яамны ТБЗГ-г хүргүүлнэ.

Зөвшөөрсөн: Төсвийн ерөнхий менежер / /

Гүйцэтгэл хянаж боловсруулсан аймагийн:

1. СЭЗБЗХэлтсийн дарга / /

2. Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн. / /

3. Төрийн сангийн мэргэжилтэн / /

2008 оны дугаар сарынны өдөр

Улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах журмын хавсралт “маят № 2”Г”

Батлав:яамны сайд. /

/

..... яамны /газрын/ шууд захиалгаар 2008 оны санхүүгийн жилд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл /....-р сарын мэдээ, сая.төгрөг/

Дд	Төсөл , арга хэмжээний нэр, байршил	Хэрэг-жүүлэх Хугацаа	Гэрээний дугаар	гэрээнд тусгасан төсөвт өртөг	2008 онд санхүүжүүлэх батлагдсан хэмжээ	Санхүүж илтийн гүйцэтгэл өссөн дүнгээр	Объектын ажлын явцын талаарх товч тайлбар
А	Б	1	2	3	4	5	6
	I.Хөрөнгө оруулалт:дүн						
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр						
1							
2							
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр						
1							
2							
	II. Их засвар:дүн						
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр						
1							
2							
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр						
1							
2							
	III.Тоног төхөөрөмж: дүн						
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр						
1							
2							
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр						
1							
2							
	Бүгд дүн						

*Гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 03-ны өдрийн дотор гаргаж Сангийн яамны ТБЗГ-т хүргүүлнэ.

Зөвшөөрсөн: Төсвийн ерөнхий менежер /

/

Гүйцэтгэл хянаж боловсруулсан яамны /газрын/:

1./Хөрөнгө оруулалт хариуцсан/ газрын дарга /

/

2. Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн. /

/

3. Санхүүжилт хариуцсан мэргэжилтэн /

/

2008 оны дугаар сарын ны өдөр

Улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах журмын хавсралт “маяг № 2”Д”

..... яам. /аймаг/-т 2008 оны санхүүгийн жилд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний ажил нь эхлээгүй буюу удаашралтай явагдаж байгаа төслүүдийн ажлын явцын талаарх мэдээлэл

/...-р сарын мэдээ, сая.төгрөг/

Дд	Төсөл , арга хэмжээний нэр, байршил	Хэрэг-жүүлэх Хугацаа	2008 оны батлагдсан хөрөнгө	Ажил эхлээгүй буюу удаашралтай байгаа шалтгаан, авч байгаа арга хэмжээ, зураг төсөв, шугам сүлжээ, газрын шийдлийн талаар
А	Б	1	2	3
	I.Хөрөнгө оруулалт: дүн			
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр			
1				
2				
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр			
1				
2				
	II. Их засвар: дүн			
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр			
1				
2				
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр			
1				
2				
	III.Тоног төхөөрөмж: дүн			
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр			
1				
2				
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр			
1				
2				
	Бүгд дүн			

*Гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 03-ны өдрийн дотор гаргаж Сангийн яамны ТБЗГ-т хүргүүлнэ. Энэ маягыг 2”б”, 2”г” маягтын хамт гаргана.

Зөвшөөрсөн: Төсвийн ерөнхий менежер /

Гүйцэтгэл хянаж боловсруулсан яам /газар, аймаг/-ийн:

1./Хөрөнгө оруулалт хариуцсан/ газар, хэлтсийн дарга /

2. Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн. /

3. Санхүүжилт хариуцсан мэргэжилтэн /

2008 оны дугаар сарынны өдөр

